

НАТО-гийн цэргийн комиссын дарга Кнуд Бартелс мэдэгдэхдээ “Цаашид НАТО шуурхай ажиллагаанд оролцох армитай болно. Энэ нь цэргийн эвслийн хөгжил оорчлолтийг ахиулж, гишүүдийн нэгдмэл байдлыг бэхжүүлнэ” гэжээ.

Эвслийн 28 гишүүн орны жанжин штабын дарга энэ долоо хоногт хоёр одор Брюссель дахь НАТО-гийн тов байранд хурал хийсэн юм. Штабын дарга нарын 168 дахь уулзалтын үеэр Кнуд Бартелс “НАТО “уян хатан сэргийлэн хамгаалалт” гэх үзэл баримтлалыг цаашид хэрэгжүүлнэ. Олон оронтой хамтын ажиллагаа орнүүлэх хэлбэрээр цэргийн зардлыг бууруулж, цэргүүдийн чадварыг нэмэгдүүлнэ. НАТО-гийн тусгай арми нь гишүүн орнуудын шилдэг цэргүүдээс бүрдэнэ” гэв.

Түүний ярьснаар тусгай арми нь НАТО-д хвчирхэг, уян хатан цэргийн хвчин чадлыг хангах аж. Мон гишүүн орон хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлж, цомхон хвчирхэг бие бүрэлдэхвнийг байгуулахад тустай юм.

Тус цэргийн эвслийн 28 гишүүн орны цэргийн тоо нийт 1.1 саяд хврсэн. Тиймээс НАТО цомхон, хвчирхэг армитай болсноор зардлаа хэмнэж чадна гэж үзэж байгаа аж.